


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
4181 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
9.8%



НИЙТ ХАДГАЛАМЖ
19.2 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
32.4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
1057 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
6%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: **5.1%**,
Инфляци: 2021 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2021 онд: **-8.3%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: **6%**
Инфляци: 2021 онд: **5.5%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: **-13.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3ax1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 9-р сарын байдлаар (1278) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 44.2 хувиар өссөн бол, зарлага 15.9 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1278 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 53.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 0.04 төгрөгөөр нэмэгджээ.

Есдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс -5.23 төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулахад 0.04 төгрөгөөр нэмэгдэж 2848.94 төгрөг болов. 9-р сард гадаад валютын нөөц 4.1 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 5.7 оны эхнээс 7.79 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 13 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 9.6%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 9-р сарын байдлаар өмнөх сараас 0.3 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар, оны эхнээс 9.2 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ түс түс өссөн байна.



Гадаад худалдааны тэнцэл 1278 сая.ам долларын ашигтай гарав.

2021 оны есдүгээр сард нийт барааны эргэлт 11,531 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 27 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 24.4 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 1278 сая ам.долларын ашигтай гарав.



9-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ



Эх сурвалж: www.mongolbank.mn

Нийт хадгаламж 2021 оны 9-р сард 19.2 их наяд төгрөг болж өмнөх сараас 34.1 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар нэмэгдсэн бол өнгөрсөн оны мөн үеэс 14.9 хувиар буюу 2489.8 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 15136.3 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 0.2 хувиар буурсан бол валютын хадгаламж 4107.2 тэрбум төгрөг болж өмнөх сараас 1.6 хувиар нэмэгдэв. Үүнээс төгрөгийн хадгаламж 79 хувь, валютын хадгаламж 21 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 30 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 19.6 хувиар буурчээ.

САРЫН ОНЦЛОХ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСӨВ

- Монголын 20 томоохон компанийн хувьцаа арилждаг Монголын хөрөнгийн биржийн үндсэн үзүүлэлт 130 орчим хувиар өсжээ. Тухайлбал, АПУ, Улсын Их дэлгүүр, Telecom Mongolia компаниудын хувьцааны ханш хамгийн их нэмэгдэв. Монголоос Хятадад нийлүүлэх ашигт малтмалын экспортоо нэмэгдүүлсэн нь (нүүрс, зэс) эдийн засаг оны эхний хагаст 6.3 хувиар өсөхөд гол нөлөө үзүүлэв. Мөн Монголын Засгийн газраас хэрэгжүүлсэн коронавирусийн нөхцөл байдлаас шалтгаалсан хямралыг даван туулах эдийн засгийн багц арга хэмжээ эерэг нөлөө үзүүлжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 4.5 ХУВИЙН ӨСӨЛТТЭЙ БАЙНА

- Монгол Улсын эдийн засгийг энэ онд 6.1 хувиар нэмэгдэнэ гэж төсөөлсөн ч 4.5 хувь болж багассан байна. Эдийн засгийн өсөлт 2022 онд 7.2 хувь байхаар төсөөлсөн нь 5.2 хувь болохоор байгаа юм. Энэ өсөлт өнгөрсөн онд 5.4 хувь болж агшжээ. "Олон улсын эдийн засаг сэргэж байна. Түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт их байгаа нь экспортын цэвэр орлогыг нэмэгдүүлэхээс гадна вакцинжуулалт эерэг үр дүн авчирна" гэдгийг Дэлхийн банкнаас мэдэгдэв.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 9-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 9-р сар 2021 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn